

Цахим шууданд

НАЛАЙХ ЦЭРГИЙН ХҮРЭЭНИЙ МАРШИЙН АВАРГААР ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 350 ДУГААР АНГИ ШАЛГАРАВ



353 дугаар анги
Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 101 жилийн ой, Монгол цэргийн өдөрт зориулсан Налайх цэргийн хүрээний төрийн цэргийн байгууллагуудын дунд зохион байгуулагдсан "Марш- тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг, бүлэг шалгаруулах тэмцээн амжилттай зохион байгуулагдан өндөрлөлөө. Тус тэмцээн нь цэрэгжлийн спортыг олон

нийтийн хүртээл болгох Налайх дүүргийн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, цэргийн алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл, үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх зорилгын дор явагдлаа. Тэмцээнд нийт 9 байгууллагын 120 орчим тамирчид хурд хүч авхаалж самбаагаа сорин

өрсөлдсөнөөс тэргүүн байрт Зэвсэгт Зэвсэгт хүчний 350 дугаар анги, тэд байрт Хилийн цэргийн 303 дугаар анги, гутгаар байрт Зэвсэгт хүчний 337 дугаар анги шалгарав. Харин эмэгтэй цэргийн алба хаагчдын төрөлд тэргүүн байрт Зэвсэгт хүчний 337 дугаар анги, дэд байрт Зэвсэгт хүчний 350 дугаар анги, гутгаар байрт Зэвсэгт хүчний 353 дугаар ангиуд тус тус байр эзэллээ. **Ахмад Б.ГАНЧУЛУУН**

"ДАЙЧИН НӨХӨД МИНЬ ОДОНГОО ЗҮҮЦГЭЭ" ӨДӨРЛӨГ ЗОХИОН БАЙГУУЛАГДЛАА



Маршийн Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 ойг тохиолдуулан Баянзүрх дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб, БЗД-ийн 16 дугаар хорооноос "Дайчин нөхөд минь, одонгоо зүүцгээ" өдөрлөг зохион байгууллаа. Тус 16 дугаар хорооны ахмадуудын дийлэнх хувь нь батлан хамгаалах салбарын хүмүүс байдаг тиймээс ч 2011 оноос эхлэн уг арга хэмжээг

зохион байгуулж хэвшсэн юм. Энэхүү өдөрлөг нь эх орныхоо тусгаар тогтнол, аюулгүй байдлыг батлан хамгаалах үйл хэрэгт эр зориг, эрч хүч, залуу насаа зориулж ирсэн ахмад дайчдынхаа яруу алдарыг сурталчилан хүндэтгэл үзүүлэх, залуу үеийнхэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилготой юм. Өдөрлөгийн үеэр Баянзүрх дүүргийн ИТХ-ын төлөөлөгч, Баян зүрх

дүүргийн ЗДТГ-ын Цэргийн шатбын дарга дэд хурандаа О.Энх-Амар, 16 дугаар хорооны дарга Б.Булганхүү нарын зочид оролцов. Тус хүндэтгэлийн арга хэмжээг нээж 16 дугаар хорооны засаг дарга Б.Булганхүү "Монгол Улсын тусгаар тогтнол, батлан хамгаалах үйлсэд нэгэн насаа зориулсан ахмад дайчдын дийлэнх хувь нь манай хороонд аж төрж, амьдардаг талархдаг. Учир нь манай хорооны залуус ахмад дайчдын туулсан замнал, түүхийг сонсож хүмүүжиж, ёс зүйтэй хүн болж төлөвшдөг гэхэд хэлсэдхгүй. Тэр ч утгаараа бид ахмад дайчдаа хүндэтгэж, залуу хойч үеэ эх оронч үзлээр төлөвшүүлэх зорилгоор энэхүү арга хэмжээг жил бүр хийдэг" гэсэн юм.

Өдөрлөгийг хүндэтгэн, ёслолын хувцасаа өмсөж, одон медалаа зүүсэн ахмадууд энэ өдрийн хамгийн тод гэрэлтэх од нь байлаа.

"ЭРДЭНЭТ ЦЭРГИЙН ХҮРЭЭ"-НИЙ АВАРГА ШАЛГАРУУЛАХ ЦОГЦОЛБОР ТЭМЦЭЭНЭЭР ...

Зэвсэгт хүчний 186 дугаар анги

"Монгол цэргийн өдөр" зэвсэгт хүчний 101 жилийн ой, Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэсний 20 жилийн ойн хүрээнд Орхон аймгийн Төрийн цэргийн болон хууль сахиулах хүчний байгууллагуудын дунд "Эрдэнэт цэргийн хүрээ"-ний аварга шалгаруулах цогцолбор тэмцээний нээлтийн ажиллагааг энэ сарын 14-ны өдөр Хангарьд цогцолборт зохион байгууллаа.

Нээлтийн ажиллагаанд Орхон аймгийн засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын захирагч С.Батжаргал, "Эрдэнэт цэргийн хүрээ"-ний дарга Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн

захирагч хурандаа Д.Жигжидсүрэн, Орхон аймгийн засаг даргын тамгын газрын цэргийн штабын дарга дэд хурандаа Б.Оюунтулхүүр, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлагууд болон бусад хүндтэй зочид оролцлоо. Нээлтийн ажиллагааны үеэр зэвсэг техникийн болон "Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд 20 жил" үзэсгэлэнг дэлгэлээ. "Эрдэнэт цэргийн хүрээ"-ний аварга шалгаруулах цогцолбор тэмцээн 2022.03.14-17-ний өдрүүдэд "Сагсан бөмбөг", "Гар бөмбөг", "Шатар", "Модон морь", "Олс таталт" гэсэн төрлүүдээр явагдана.

Ахмад О.ОТГОНЦЭЦЭГ



Хэнтий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб ПАУЭРЛИФТИНГИЙН АНХДУГААР ТЭМЦЭЭН БОЛЛОО



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан аймгийн аварга шалгаруулах анхдугаар тэмцээнд амжилттай болж

өндөрлөлөө. Тус тэмцээнийг аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн цэргийн штаб болон аймгийн "Хаадын хүч" Пауэрлифтингийн холбоо хамтран зохион байгуулан

явууллаа. Тэмцээний үеэр Пауэрлифтингийн спортыг сурталчлан таниулах, түгээн дэлгэрүүлэхэд үнэтэй хувь нэмрээ оруулж, олон улс, тив дэлхийн чанартай тэмцээн уралдаанд амжилттай оролцож, Хан Хэнтий нутгийнхаа нэрийг өндөрт өргөж яваа ази, дэлхийн аварга 11 тамирчинд аймаг орон нутгийн зүгээс баяр хүргэж, хүндэтгэл үзүүлэв. Тус тэмцээнд нийт 100 гаруй тамирчид хүч чадлаа сорин өрсөлдсөнөөс багийн нийт дүнгээр Хадун фитнес тэргүүн байр, аймгийн Цагдаагийн Газар 2 дугаар байр, Биеийн тамир, спортын газар 3 дугаар байрт тус тус шалгарлаа.

Тус тэмцээнд нийт 100 гаруй тамирчид хүч чадлаа сорин өрсөлдсөнөөс багийн нийт дүнгээр Хадун фитнес тэргүүн байр, аймгийн Цагдаагийн Газар 2 дугаар байр, Биеийн тамир, спортын газар 3 дугаар байрт тус тус шалгарлаа.

ЭР ЦЭРГИЙН АЛБАНД ХАМТДАА МОРДСОН АХ ДҮҮ ХОЁР ЭЭЖТЭЙГЭЭ УУЛЗЛАА



Өнгөрсөн 2021 онд Хэнтий аймгаас хугацаат цэргийн албанд мордсон дайчдыг ар гэрийн төлөөлөлтэй уулзуулах, тэдний алба хааж буй нөхцөл байдалтай танилцуулах, Зэвсэгт хүчин, Хилийн цэргийн анги байгууллагыг орон нутагт сурталчлах, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэх зорилготой "Уулзахын жаргал" нэвтрүүлэг бэлтгэх үйл ажиллагааг Зэвсэгт хүчний

327 дугаар анги, Хилийн цэргийн 0198 дугаар ангийн дэмжлэгтэйгээр Дорнод аймгийн Чойбалсан хот, Халхгол суманд зохион байгуулаа.

Бидний зорин очсон Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн дэд түрүүч Г.Ганбаяр, Хилийн 0198 дугаар ангийн байлдагч Г.Төгсбаяр нарын ээж Э.Пүрэвсүрэн Хэнтий аймгийн Хэрлэн суманд амьдран суудаг бөгөөд аймгийн Нэгдсэн эмнэлэгт

эмэгтэйчүүдийн их эмчээр ажилладаг нэгэн юм.

Тэрбээр 4 хүүтэй бөгөөд ууган хүү нь Зэвсэгт хүчний 032 дугаар ангид хугацаат цэргийн алба хаасан бол удаах 2 хүү нь дээрх ангиудад нэгэн зэрэг алба хааж байгаа аж.

Харин бага хүү нь өдгөө 7 настай, ерөнхий боловсролын сургуулийн сурагч юм. Ийнхүү хөвгүүдээ эр цэргийн албанд зэрэг мордуулсан ээж хоёр хүүтэйгээ уулзсан уулзалтын хажуугаар аймгийн Засаг даргын тамгын газрын хэвлэл мэдээллийн албаныхан Зэвсэгт хүчин, Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагаа, хугацаат цэргийн албан хаагчдын ар гэрээр дамжуулан орон нутаг төдийгүй улс орон даяар сурталчлах зорилготой бүрэн хэмжээний нэвтрүүлэг бэлтгэсэн бөгөөд "Монгол цэргийн өдөр"-ын баярын өдрүүдээр орон нутгийн телевизээр "Уулзахын жаргал" нэвтрүүлгээр үзэгчдийн хүртээл болох юм.

"АЛДАР"-ЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ХҮЧИТ БӨХИЙН БАРИЛДААН БОЛЛОО



Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойд зориулсан "Алдар" спорт хорооны аварга шалгаруулах улс, аймгийн цолтой хүчит бөхийн барилдаан өчигдөр болж өндөрлөлөө. Тус үйл ажиллагаанд Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны БХЗГ-ын дарга хурандаа Б.Түвшинтөр, "Алдар" спорт хорооны дарга хурандаа Г.Өсөхбаяр тэргүүтэй албаныхан оролцлоо. Сорилго барилдааныг нээж хурандаа Г.Өсөхбаяр "Монгол бөх монголчуудын ахуй амьдралаас үүсэн бий болсон болохоор бидний өнө нөхөд хайрлан хамгаалж, хөгжүүлж, түгээн дэлгэрүүлэх ёстой өв соёл мөнөөс мөн. БХЯ-ны "Алдар" спорт хороо нь үүсэн

байгуулагдсан цагаасаа хойш 76 жилийн түүхэндээ үндэсний бөхийн спортыг дэлгэрүүлэн хөгжүүлж, сурталчилж, эр цэргийн албанд татагдан ирсэн олон шилдэг залуучуудыг сонгон шалгаруулж бэлтгэж иржээ. Түүнчлэн 3 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойн хүчит 256 бөхийн барилдааныг, 6 дугаар сард цэргийн цол чимэг олгох Бүх цэргийн наадмыг Монгол бөхийн өргөөнд зохион байгуулна. Өнөөдөр энэ зааланд зодоглох "Алдар"-аараа овоглосон хүчит бөхчүүддээ уран мэхийг уралдуулан амжилттай сайн барилдахыг хүсэн ерөөе" гэв. Ийнхүү үргэлжилсэн тус барилдааны Их шөвөгт Ц.Одбаяр заан Х.Гантулгыг амлан барилдаад

хөмрүүлж унасан бол Б.Цэдэнсодном аймгийн заан Э.Батмагнайтай тунаж, сэнжиг булаацалдаж, сугадаагаа авах гэж хэдэнтээ тэмцэлдээд сэнжиг өгүүт зөрөөд зүүн хавирчихав. Ингэж Өвөрхангай нутгийн хоёр идэр харцага Алдар спорт хорооныхоо барилдаанд тэргүүн байрын төлөө үлдлээ. Үзүүр түрүүнд харин хоёр харцагын барилдаан харьцангуй удсангүй. Хүрэл-Очирын Гантулгын дагуулж дунгуулдаж татсан барилдаан хурдан бөгөөд сонирхолтой болов. Уран барилдааны тусгай шагналыг Завхан аймгийн Цэцэн-Уул сумын харьяат Жаргалсайхан залуу бөх Нямсүрэнгийн Амгаланбаатарт гардуулсан юм. Ийнхүү "Алдар" спорт хорооны бөх түрүүлснээр энэ удаан барилдаан өндөрлөлөө.

Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон Индекс: 10018
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)